

	<p align="center">“ПРАКТИКАЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ</p>	Батлагдсан огноо: 2023.05	
		Мөрдөж эхлэх: 2023.05.	
		Код: ПДЖ-	Хуудас:
Хариуцагч:	Захиргаа хүний нөөцийн алба		
Саналаа тусгасан:	Гүйцэтгэх захирал Д.Нямрагчаа Даатгалын газрын захирал Т.Уранжаргал Санхүү, хөрөнгө удирдлагын газрын захирал Б.Хишигбаяр Бизнес хөгжлийн газрын захирал Г.Отгонбаяр Захиргаа хүний нөөцийн албаны дарга Б.Лхагвабаатар ДХЭУ-ын албаны дарга М.Замбагацэцэг Технологи хөгжүүлэлтийн албаны дарга Б.Бүрэнтэгш		
Боловсруулсан:	Хууль, нөхөн төлбөрийн газрын захирал Б.Амарбаясгалан		

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Бизнесийн ёс зүйн дүрмийн зорилго нь Практикал даатгал ХХК-ийн даатгалын зах зээлийн үйл ажиллагаанд оролцохдоо баримталвал зохих ёс зүйн хэм хэмжээг тогтоох, түүний хэрэгжилтийг хангах, хариуцлага тооцохтой холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэ дүрэм нь Санхүүгийн зохицуулах хорооноос батласан “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”, Очир Ундраа группын “Байгууллагын бизнесийн ёс зүйн дүрэм” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад актаас бүрднэ.
- 1.3 Ёс зүйн дүрмийн хамрах хүрээ нь:
 - 1.3.1 ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга
 - 1.3.2 Гүйцэтгэх захирал, удирдлагын хорооны гишүүд
 - 1.3.3 Компанийн үндсэн болон гэрээт ажилтнууд
 - 1.3.4 Даатгуулагч иргэн, хуулийн этгээд
 - 1.3.5 Бизнесийн түншүүдэд нэгэн адил хамаарна.
- 1.4 Практикал даатгал ХХК нь үйл ажиллагаандаа дараах мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчмыг баримталж ажиллана.
 - 1.4.1 Хууль, шударга ёсыг дээдлэх
 - 1.4.2 Ил тод байх
 - 1.4.3 Даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
 - 1.4.4 Даатгуулагчид шуурхай үйлчлэх
 - 1.4.5 Шударга өрсөлдөөнийг эрхэмлэх
 - 1.4.6 Даатгалын зах зээлд оролцогчийн эрх ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах
 - 1.4.7 Даатгалын салбарын мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, дээшлүүлэх

ХОЁР. ПРАКТИКАЛ ДААТГАЛ ХХК-ийн СУУРЬ БОДЛОГО

- 2.1 АЛСЫН ХАРАА: Шинэчлэл, манлайлалыг хослуулан, технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, тогтвортой хөгжилд хувь нэмэрээ оруулна.
- 2.2 ЭРХЭМ ЗОРИЛГО: Бид чанартай, инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээг хамгийн найдвартай, хурдан үзүүлж, харилцагчиддаа сэтгэл амар байх боломжийг олгоно.
- 2.3 ҮНЭТ ЗҮЙЛС:
 - 2.3.1 Чин сэтгэл - / Итгэл даах, өөриймсөг хандлага /
 - 2.3.2 Ёс зүй
 - 2.3.3 Ур Чадвар - /Мэргэжлийн, хурдан шуурхай байдал/
 - 2.3.4 Хамтын ажиллагаа - /Харилцагчидтай байнгын холбоотой байж тэдний эрсдэлийн зөвлөгч байх/
 - 2.3.5 Тэмүүлэл - / Бүтээлч сэтгэлгээ, санаачлагатай байдал /
- 2.4 БАРИМТЛАХ ЗАРЧИМ: Бид бизнесийн үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг нэн тэргүүнд баримталж ажиллана. Үүнд:
 - 2.4.1 Хууль, дүрмийг чанд мөрдөх
 - 2.4.2 Хүндэтгэлтэй байх
 - 2.4.3 Хариуцлагатай байх
 - 2.4.4 Оролцоог дэмжих
 - 2.4.5 Тасралтгүй шинэчлэгдэгч байх

ГУРАВ. ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

- 3.1 Практикал даатгал ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан Даатгалын зах зээлийн ёс зүйн журмын 3 дугаар зүйлд заасан ёс зүйн түгээмэл хэм хэмжээг мөрдлөг болгоно.
- 3.2 Харилцагч иргэн, хуулийн этгээд болон бизнесийн түншүүдтэй харилцахдаа дээр дурдсан ёс зүйн түгээмэл хэм хэмжээнээс гадна дараах ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:
 - 3.3 ХҮНИЙ ЭРХ
 - 3.3.1 Компани, түүний ажилтан нь хүний эрхийг хүндэтгэж, аливаа хэлбэрээр зөрчихгүй байхыг эрхэмлэх бөгөөд Үндсэн хуулийн үзэл санаа болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэмждэг.
 - 3.3.2 Иргэн, хуулийн этгээдтэй харилцахдаа хүндэтгэх ёсыг сахиж, нэр төрийг нь гутаах, бүдүүлэг үг, үйлдэл гаргахыг хориглоно.
- 3.4 ТӨР ЗАСАГ
 - 3.4.1 Бизнесийн орчинд нөлөөлөх төр засгийн бодлого, хууль эрх зүйн асуудалд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, аливаа өөрчлөлт, шинэчлэлтийг соргоогоор мэдэрч, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ.
 - 3.4.2 Бизнесийн үйл ажиллагааныхаа талаар үнэн зөв мэдээллийг төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шаардсан хугацаанд гаргаж өгч, хамтран ажиллана.
- 3.5 МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

- 3.5.1 Албан үүргийн шаардлагаар олж мэдсэн, ажил горилогчид, бизнесийн түншүүд, харилцагчдын хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх, хадгалах, хамгаалах орчин нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- 3.5.2 Эрх бүхий байгууллагаас харилцагч болон бизнесийн түншүүдтэй холбоотой мэдээллийг шаардах тохиолдолд мэдээллийн нууцлалд тавигдах шаардлагыг бүрэн хангаж ажиллана.

3.6 ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН

- 3.6.1 Бид зах зээл дээр шударга, ёс зүйтэй өрсөлдөж, Өрсөлдөөний тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлж ажилладаг,
- 3.6.2 Өрсөлдөгч байгууллагын талаар худал мэдээлэл түгээх болон өрсөлдөгчийн эсрэг хууль бус үйл ажиллагаанд оролцохгүй,
- 3.6.3 Өрсөлдөгчдийн нууц мэдээллийг хууль бус, ёс зүйгүй арга, хэлбэрээр олж авахгүй. Зөвхөн хууль ёсны дагуу мэдээлэл авна.
- 3.6.4 Харилцагч нартаа ижил тэгш боломж олгох, аль нэг талд нь давуу байдал бий болгохгүй байхад анхаарч ажиллана.
- 3.6.5 Бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааг хуулийн хүрээнд явуулах, худал мэдээлэл агуулсан буюу буруу ойлголт төрүүлэхүйц зар сурталчилгаа явуулахгүй.

3.7 АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

- 3.7.1 Ажилтан бүр итгэл даахуйц үнэнч байж ашиг сонирхлын зөрчил үүсч болох бүх нөхцлийн талаар удирдах ажилтандаа нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Үүнд тухайн ажилтны хувийн эсхүл ойр дотны хүмүүсийн ашиг сонирхол компанийн ашиг сонирхолтой давхцаж болох бүх нөхцөл орно.

3.8 АВИЛГА, ХЭЭЛ ХАХУУЛЬ

- 3.8.1 Хуулиар хориглосон буюу авилга, хээл хахуулийн шинжтэй аливаа шан харамж, урамшуулал, дэмжлэг туслалцаа, хүлээн авалт, баяр цэнгэлийн шинжтэй арга хэмжээнд оролцох, хууль бус хэлэлцээр тохиролцоо хийх, орчин нөхцлийг бүрдүүлэх, эдгээр үйлдэлтэй эвлэрч хайхрахгүй өнгөрөх, нуун дарагдуулахыг хориглоно.
- 3.8.2 Компани нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулах давуу эрхийг хууль бусаар олж авах, хадгалж үлдэх зорилгоор шууд буюу шууд бусаар аливаа төлбөр болон үйлчилгээг санал болгох, амлахыг хориглоно.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- 3.9.1 Бид санхүүгийн тайлангаа үнэн зөв, бүрэн, ойлгомжтой байдлаар цаг хугацаанд нь тайлагнана.

3.10 ОЮУНЫ ӨМЧ

- 3.10.1 Зохиогчийн эрх, патентийн эрх, бизнесийн нууц зэрэг мэдээллүүд нь компанийн оюуны өмчид хамаарна. Ажилтан бүр компанийн оюуны өмчийг хамгаалах үүрэгтэй.
- 3.10.2 Компанийн оюуны өмчийг зүй бусаар ашиглах, зөвшөөрөлгүйгээр бусдад тараах, ашиглах, хуулбарлахыг хориглоно.

3.11 МӨНГӨ УГААХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ, ТЕРРОРИЗМИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ

3.11.1 Бид мөнгө угаах, үй олноор хөнөөх зэвсэг, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой дүрэм, журмын дагуу хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

- 4.1 Энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн байж болзошгүй талаар харилцагч иргэн, хуулийн этгээдээс гомдол, мэдээлэл ирүүлсэн, эсхүл хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн тохиолдолд холбогдох хууль, дүрмийн дагуу хянаж шийдвэрлэнэ.
- 4.2 Ёс зүйн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3.1-ээс 1.3.3-т заасан ажилтнууд ёс зүйн дүрмийг дагаж мөрдөөгүй болох нь тогтоогдвол холбогдох хууль болон компанийн дотоод журмын дагуу хариуцлага тооцно.